

**01 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ****Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Төрийн үйлчилгээний чиглэлээр:** Тамгын газрын албан хаагчдын 2023 оны төлөвлөгөө болон ТЖАХ-дын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж ажилласан.

Цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажлыг 2023 оны 01/5-01/25ны хооронд зохион байгуулж ажилласан. Сумын түүхт 100 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилж ажлын хэсгийн хурлыг хуралдуулж салбар хороодын ажлын хэсгийн дарга нарийн бичгийн дарга нарт нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж танилцуулж батлуулах үүрэг чиглэлийг өглөө.

Улсын бүртгэл: 1 сард төрсний бүртгэл 7, нас барсны бүртгэл 4, гэрлэлтийн бүртгэл 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 15, иргэний үнэмлэх олголтын бүртгэл 24, шилжилт хөдөлгөөний бүртгэл 1, төрсний гэрчилгээ дахин олгох 2, иргэний бүртгэлийн лавлагаа 9, иргэний үнэмлэх хүчингүй болгох бүртгэл 10 хийгдсэн байна. Иргэний бүртгэлийн тоон мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээг 1 сарын 25 ны өдөр улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж ажилласан. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тоон мэдээг 1 сарын 25 ны өдөр улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж ажилласан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан архивын улсын тооллогын ажлын хүрээнд 3090 хувийн хэргийг тоолсон.

**Хууль эрх зүйн чиглэлээр:** Үндсэн хуулийн үзэл баримтлалыг болон салбар хуулиудын агуулгыг тайлбарлан таниулах зорилгоор Удирдамжийг тамгын газрын даргаар 2023 оны 01-р сарын 11 өдөр батлуулан төсөвт байгууллагуудад хүргүүлэн 2023 оны 01-р сарын 16 ны өдрийн 13.00 цагаас Рашаантын нууран дээр Хууль сурталчилах Эрүүл агаар өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд төсөвт 3 байгууллагуудын 45 албан хаагчид баг бүрдүүлж хамрагдсан. Хууль сурталчилах арга хэмжээний удирдамжийн дагуу багуудын дунд мөсний шагай харвах тэмцээн, орс таталтын тэмцээн, мөсөн дээр Танго бүжгийн тэмцээнүүдийг зохион байгуулсан. Нийт иргэд албан байгууллагуудын төлөөлөл 87 хүн хамрагдаж үзэж сонирхсон.

Соёлын төвд орой 19 цагаас Үдшийн цэнгүүн зохион байгуулсан. Нийт тэмцээнд оролцсон байгууллагууд үндсэн хуулийг сурталчилан таниулах зорилгоор жүжигчилсэн тоглолт урлагын номерийг иргэдэд үзүүлж сонирхуулсан. Үүнд ЕБС-ийн баг Тусгаар тогтнолын талаар иргэдэд үзүүлбэр үзүүлж бэлдсэн гарын авлагыг тараасан. Соёлын төв амьд явах эрхийг харуулсан урлагын тоглолтыг сонирхуулж, гарын авлага поршурыг ирсэн иргэдэд тараасан. ЗДТГ-ын баг 1924,1940,1960, 1992 оны үндсэн хуулийг сурталчилсан урлагийн тоглолтыг жүжиглэсэн байдлаар иргэдэд танилцуулж гарын авлага тараасан. Мөн байгууллагууд урлагын номер хөгжөөнт тоглоом, үндсэн хуулийн асуулт хариулт зэрэг сонирхолтой арга хэмжээг иргэд албан хаагчдад үзүүлж сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан. Үдшийн цэнгүүнд нийт 97 төрийн албан хаагч, иргэд оролцсон.

Үндсэн хуулийн өдөрт зориулсан Хууль сурталчилах арга хэмжээний зар мэдээллийг иргэдэд сумын ЗДТГ-ын фесбүүк хаяг болон Мөнххаан сумын зар зарлалын групп байгууллагуудын цахим хаягуудад байршуулж мэдээлж ажилласан.

Энэ арга хэмжээний зардалд ЗДТГ-аас 200,0 мян төгрөгийн шагналын санг шийдвэрлэж дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн соёлын төв техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж хамтран ажилласан.

Хууль сурталчилах арга хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээний 4 төрлийн нийлбэр оноо болон идэвх оролцоо, тараасан гарын авлага зэргийг шүүгчид үнэлэн шалгаруулахад 1-р байрыг ЗДТГ

2-р байрыг Соёлын төвийн баг хамт олон эзэлж амжилттай оролцсон.

**Хоер: Нийгмийн бодлогын хүрээнд**

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Насны хишигт шинээр 17 иргэний бүртгэсэн.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сарын 16-нд хуралдуулж ахмадын асаргаа сунгах 2 иргэний хүсэлт, Албан газрын харьяалалгүй ахмадын жагсаалтыг хэлэлцэн 352 ахмадын хүндэтгэлийг ehalamj.mn системд бүртгэлээ. ХЭБҮ-нд энэ сард 6 өрхийн 29 иргэний 296.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт 68 иргэн шалгуулснаас өөрийн биеэр 36, утсаар 32 иргэн үйлчлүүлсэн байна.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангаас олгогдох жижиг зээлийн мэдээллийг 34 иргэнд хүргэсэн. Одоогоор 4 иргэний төслийг хүлээн аваад байна.

**ЕБС** 2022-2023 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг амжилттай эхлүүлэн ажиллаж байна. Энэ хичээлийн жилд тус сургуулийн 91 багш ажилтан 1017 сурагчдад боловсролын үйлчилгээ үзүүлж байна.

Энэ сард сурагчдын 1-р улирлын амралтбн хугацаанд дотуур байранд- 12,6 сая төгрөг, хичээлийн 1-р байранд-3,6 сая төгрөгийн засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Сургуулийн дотоод журамд заасны дагуу ЕБС-ийн 90-н багш ажилчдад нүүрс түлээний дэмжлэг 10 шуудай нүүрс олгосон.

Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох нь" төслийн 3-р шатанд 3-н төсөл тодруулгатай тэнцсэн байна.

Мөнххаан сумын Ерөнхий боловсролын захирал , бага ангийн сургалтын менежер , бага ангийн 1 багшийн хамт 2023 оны 1 сарын 26,27-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо улсын хэмжээний 9 сургуульд хэрэгжиж байгаа ФИНЛЯНДЫН ЭДҮТЭН ПЛАТФОРМЫН МОНГОЛ УЛС ДАХЬ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ- Д ХАМРАГДАЖ БАЙНА.

**Хүүхдийн цэцэрлэг:**

#### **1. Багш нарын сургалт, түгээн дэлгэрүүлэлт**

Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт эрүүл мэндийн боловсролыг тусган хэрэгжүүлэх нь” сэдэвт арга зүйн сургалтад эрхлэгч, арга зүйчийн хамт хамрагдлаа. Бусад багш нартаа уг сургалтыг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрт тусгаж, үр дүнг хэрхэн тооцож ажиллах талаар хэлэлцүүлэг хийлээ.

Төсөвт байгууллагын дарга, нябо нарт “Байгууллагын төлбөр тооцоог бүрэн цахимжуулах, нягтлан бодогчдын ажлын ачааллыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, зайнаас ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс төрийн сангийн төлбөр тооцооны цахим / Портал/ системийн сургалтыг 01 сарын 18-нд хийж эрхлэгч хамрагдлаа.

"БШУ- ны сайдын 2022.12.20 -ны өдрийн А/545 тушаалыг танилцуулах сургалт, мэдээллийг байгууллагын ёс зүйн зөвлөл зохион байгууллаа.Сургалтад хамрагдсанаар шинээр орсон ажилчид ажлын байран дээр ёс зүйн алдаа гаргавал ямар хариуцлага хүлээдэг, ёс зүйн ямар хэм хэмжээ баримтлах ёстой зэргийг мэдэж авсан. Сургалтанд нийт 34 багш, ажилчид хамрагдлаа.

## 2. Хөрөнгө оруулалт, дэмжлэг .

БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа иргэн Ө.Чинбаяр ,тус цэцэрлэгийн хүүхдүүдийн тоглонгоо хөгжих үйлийг дэмжиж 5.000.000 төгрөгийн тоглоомын хандив өгсөн ба, энэхүү хандив дэмжлэгийг хамт олны намрын аяллын үеэр 10 бүлгийн багш нарт сугалуулж, 1багш азтан болсон тул тухайн багшийн ангид 4.000.000 төгрөгийн тоглоом, багшид нь 1.000.000 төгрөгийн таблет өгч, багш болон хүүхдүүдийн сурах, сургах үйлсэд маш том дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалт хийгдлээ.

Аймгийн засаг дарга “Онлайн кабенит” төсөл хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 169,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөдөөгийн 13 сумын цэцэрлэг болон Насан туршийн боловсрол төвд ухаалаг дэлгэц гардуулж өглөө. Цэцэрлэгүүд ухаалаг дэлгэцтэй болсноор бага насны хүүхэд болон багш сурагчид, иргэд орон зайнаас үл хамааран цахимаар суралцах боломж бүрдэж байна. Аймаг, орон нутаг, сумд мэдээлэл туршлагаа солилцоход тус дэлгэц олон талын ач холбогдолтой. Мөн энэ үеэр Аймгийн Засаг дарга М.Идэрбат боловсролын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл хийж, тулгамдаж буй асуудлын талаар санал бодлыг нь сонслоо. Үүнд эрхлэгч зуны цэцэрлэг ажиллуулах зорилгоор 2 гэртэй болох хүсэлт тавьж шийдвэрлүүлээ.

## Спорт тэмцээн

БШУГ-аас зохион явуулсан "Багш цом-2022" нөхөрсөг бооцоот тэмцээн сагс, волейболын төрлөөр 12-р сарын 27-28-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт зохион байгуулагдаж, волейболын төрөлд тус цэцэрлэгийн эрэгтэй баг 3-р байр , эмэгтэй баг 1-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.Энэ удаа тамирчдынхаа хоол унд, бооцооны мөнгийг хамт олны хуримтлалаас шийдвэрлэлээ.

Баруун-Урт сумын ТЭРГҮҮНИЙ МАНДАРВАА VIII цэцэрлэг -ийн хамт олон, 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Гар бөмбөг”-ийн тэмцээнд 18 баг тамирчид оролцож,манай цэцэрлэгийн Б.Урансайхан ахлагчтай баг тамирчид тэргүүн байр эзлэн, "Шилжин явах цом"-ын эзэд болсон. Мөн "Шилдэг довтлогч"-оор нярав С.Тэмүүлэн шалгарсан.

## 5. Хүүхдийн хөгжил, хэрэгцээнд

Эрхлэгч Д.Ариунмөнх “ХҮҮХЭД БҮР ЁС ЗАНШЛАА МЭДДЭГ БАЙХ ХЭРЭГТЭЙ” цуврал зурагт постер хийж, байгууллагын цахим хуудсанд байршууллаа. Уг постерт: Удахгүй болох сар шинийн баярыг угтаж , сургуулийн өмнөх насны хүүхдүүддээ уламжлалт баярын талаар мэдлэг олгох зорилгоор энэхүү 10 цуврал зурагт мэдээллийг багтаасан.Эцэг эх асран хамгаалагч, цэцэрлэгийн багш нар хүүхдүүддээ уншиж өгөөд, зураг дээрх үйл явдал, өмссөн хувцас, ширээн дээрх идээ будаа, бусад зүйлсийн талаар тайлбарлаж өгөх боломжтой. Мөн хүүхдүүд өөрсдөө зураг харж ярилцаад үгийн баялаг, хэл ярианы чадвараа хөгжүүлж болохуйц юм. Сар шинийн холбогдолтой шүлгийг хавсаргаж өгсөн, А4 цаасны хэмжээгээр хийсэн учир хэвлэж аваад ашиглах боломжтой.

Сургуулийн амралтаар удаан хугацаагаар чөлөө аваад явсан малчдын хүүхдүүддээ хэвлэмэл материал болон аюул ослоос өөрийгөө хэрхэн хамгаалах зурагт зөвлөмж зэргийг хүргүүлсэн. Нийт СӨН-ны 65 хүүхдэд хүргэсэн.

## 6. Бүтээлч үйл ажиллагаа

Ажиллах орчноо сайжруулах, хүүхдийн сурч хөгжих орчныг тохижуулах зорилгоор багш ажилчдад “Бүтээлч 7 хоног” аян зарлаж, дүгнэн хэлэлцлээ. Уг үйл ажиллагаагаар нэг нэгэндээ сурсан мэдсэнээ хуваалцах, арга туршлагаасаа түгээн дэлгэрүүлэлт хийлээ.

**Соёл:** Аймгийн соёл урлагийн газарт 2022 оны статистик тоон мэдээллийг хүргүүллээ. Соёл урлагийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд 3 албан хаагч хамрагдлаа. Байгууллагын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн аймгийн Аудитын газар хүргүүлэхээр ажиллаж байна.

Байгууллагын ажилтан албан хаагчдад шинээр хэрэгжиж буй хууль тогтоомжийн чиглэлээр сургалтыг 1 удаа зохион байгуулан ажиллалаа.

Соёл урлагийн нэгдсэн 3 арга хэмжээ зохион байгуулагдсан үүнээс гадны 1 тоглолт нийт 459 үйлчлүүлэгч хамрагдсан байна

**НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Номын сангийн статистик тоон мэдээллийг нэгтгэн хүргүүллээ. Номын сангийн фондны тооллогыг соёлын төвийн даргын 2023 оны 01 сарын 05-ны өдрийн А\01 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг тооллогын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Номын сангийн явуулын үйлчилгээг 3 удаа хүргэн танхим болон явуулын үйлчилгээгээр 74 иргэнд 101 номоор үйлчиллээ. Аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулсан цахим сургалтанд номын санч хамрагдлаа.

2023 онд номын сангийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан номын санчийн 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталлаа.

**ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Хөгжим бүжгийн багшийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж 2023 оны дугуйлан сургалтын чиглэлийн дагуу шинэчилсэн бүртгэлийг зохион байгуулан ажиллаж байна.

Хөгжмийн багш С.Бат-Орших “Талархал” уран бүтээлийн бие даасан тоглолтыг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** 2023 оны 01 сарын 25-ны байдлаар 29 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 22 насанд хүрэгчид, 3 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Амбулаторийн үзлэг 534, урьдчилан сэргийлэх үзлэг 120 байна.

2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж удирдлагад танилцуулж батлуулан ажиллаж байна. Үүнд: 8 үйл ажиллагааны төлөвлөгөө, сүрьеэгийн талаар хийх ажлын төлөвлөгөө, дотоодын сургалтын төлөвлөгөөг гаргаж батлууллаа. “Хүүхэд – аюулгүй орчин” аяны төлөвлөгөө боловсруулан батлуулж сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Ахуйн осол гэмтлээс сэргийлэх, иргэдэд мэдээлэл хүргэх гарын авлага, тараах материалын эхийг бэлтгэж иргэдэд мэдээлэл хүргэж байна.

Түргэн тусламжийн дуудлага 85 ирснээс алсын дуудлага–10, ойрын дуудлага 75 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

**Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:**

Аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МЭТ-ийн улсын байцаагч, тархвар зүйч, хувийн мал эмнэлгийн малын эмч нар хамтран сумын

төвийн айл өрхүүдээр 3 өдөр явж аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг танилцуулж гэрийн тэжээвэр нохойн бүртгэл хийж гэрчилгээжүүлэн туулгалт хийж ажилласан. Нийт 392 өрхөөр орж 98 нохойнд гэрчилгээжүүлэлт хийж туулгалт өгсөн. Мөн 15 нохойд вакцин хийсэн.

Сумын өвс тэжээлийн нөөцөд байсан 5000 боодолд өвсийг хөнгөлөлттэй үнээр малчдад олгож эхлээд байна. 1 өрхөд 5 боодол өвс 4000,0 төгрөгөөр олгож байна. Одоогийн байдлаар 5 багийн 591 өрхөд 2955 боодол өвсийг олгоод байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.